

О. Чулуун
М. Зэнээ

МАОГИЙНХНААС ӨВӨР МОНГОЛД ЯВУУЛЖ БАЙГАА ХҮЧЭЭР УУСГАХ БОДЛОГО

Түүхийн урт удаан хугацаанд их үндэстний дээрэнгүй үзэл баримталж ирсэн хятадын эзэн хаад, ноёлогч ангийнхан хөрш зэргэлдээ улс орныхоо нутаг дэвсгэрт байнга өнгөлзөн, тэдгээр ард түмний амар тайван аж төрөх явдалд саад тотгор хийж, дайн түрэмгийлэл үйлдсээр иржээ.

Хятадын эзэрхэгчүүдийн тэрхүү түрэмгийлэлд монголчууд, ялангуяа монголын өмнөд хэсэг болох Өвөр Монгол ард түмэн бусдаас илүү их өртөж ирсэн түүхтэй. Хятадын эзлэн түрэмгийлэгчид монгол ард түмнийг өөртөө нэгтгэн хүчээр уусгах бодлогоо хэрэгжүүлэхийг санаархаждаа юуны урьд хүчээр халдан түрэмгийлэхийг санаархан оролдож тэр нь бүтэхгүй болохоор монгол угсаатныг өөр хооронд нь яс хаян мөргөлдүүлж хүчийг нь сулруулж байгаад түрэмгийлэн эзлэх хорт бодлого явуулж, бага багаар эзлэн авсан нутагтаа сэм газар хагалбарлан хятад тариачдыг нүүлгэн суурьшуулах ажлыг хийж ирсэн байна.

Хятадын их гүрний үндсэрхэг дээрэнгүй үзэлтнүүд түүхийн тодорхой үед монголчуудыг хүчээр эрхшээлдээ оруулан захирах гэж оролдохдоо «И и чжи и»— («нэг бүдүүлгийг нөгөө бүдүүлгээр хазаарлах»), «Цань-ши» (хүр хорхой модны навчийг мэрж дуусгах адил хөршийнхөө нутгаас бага багаар авсаар эзлэх») зэрэг бодлого баримталж ирсэн билээ. Чухам ингэж нэг нүүдэлчдийн эсрэг нөгөө нүүдэлчин ард түмнийг тухирах, монгол газар нутгийг нь бага багаар түрэн эзлэх замаар хятад газар болгон хувиргах ажлыг хийсээр иржээ. Энэ байдлаас болж монголчуудын дунд «Улаан буудай нь мал, билчээр хоёрыг залгина» хэмээн зүйрлэсэн үг хэлэлцэгдэн дэлгэрэх болсон учиртай бүлгээ.

Өвөр Монгол ард түмний түүхийн өнгөрсөн үе нь нийт монголын ард түмний тэмцэл хөдөлгөөний түүхтэй салшгүй холбоотой.

Аугаа их Октябрийн хувьсгалын нөлөөгөөр 1921 онд Монголд ардын хувьсгал ялж БНМАУ үүсэн байгуулагдсан тэр үеэс Өвөр Монголд үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн хүчтэй өрнөж тухайн үед ихээхэн амжилт олж байжээ. 1945 онд Зөвлөлт-Монголын арми Өвөр Монгол болон Хятадын зүүн хойт хэсгийг японы түрэмгийлэгчдийн ноёрхлоос чөлөөлсөн нь Өвөр Монгол ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн амжилт олоход таатай нөхцлийг бүрдүүлж өгчээ. Гэтэл эрх чөлөөний төлөө Өвөр Монголчуудын тэмцэл тэдний нийтлэг хүсэл эрмэлзлэлээс огт ондоо байдлаар эргэсэн юм.

ХКН анх байгуулагдаж байх үедээ үндэстний асуудлыг зөвөөр шийдвэрлэх талаар нилээд хүчин чармайлт гаргаж, зарим нэг тогтоол заалт хүртэл гаргаж байжээ. Тийм тогтоол заалтыг нийт хятадын ард түмэн ялангуяа хятад биш ард түмэн ихэд талархан дэмжиж байв. Гэтэл 1930-аад оны дунд үеэс ХКН-ын удирдлагад Мао Зэдүн тэргүүтэй үндэсний явцуу үзэлтнүүд гарч ирснээс хойш уг асуудал амьдралд өчүүхэн ч хэрэгжихгүй болжээ. Мао Зэдүн үндэстний асуудлыг шийдвэрлэх цорын ганц «марксч-ленинч» зөв зам бол үндэстний өөртөө засан тохинох

биш, харин «хуваагдашгүй нэгдэлтэй» хятадын орон нутгийн автономитөдий байвал зохино гэж үзэж байв.

Өвөр Монгол ард түмний эрх чөлөөний тэмцэл ид өрнөж байх явцад тэдний өмнө ХКН-аас үндэстний талаар хойшид явуулах бодлогыг дагаж автономит район байгуулах нэг зам, эсвэл биеэ даасан тусгаар улс байгуулах өөр нэг зам хоёрын аль нэгийг сонгон авах явдал тулгарсан байна.

Тухайн үедээ энэ хоёр чиглэлийн аль аль нь чөлөөлөгдсөн ард түмний хүсэл эрмэлзлэлийг адилхан тусгасан шинжтэй байлаа. Өвөр Монгол ард түмэн энэ хоёр чиглэлийн аль ашигтайг нь сонгон авах байсан тэрхүү эгзэгтэй үед маогийнхны шууд оролцоотой Өвөр Монголын автономит район гэгчийг байгуулах чиглэл нь давамгайлан гарч ирсэн байна. Хятадын харьяанд автономит район байгуулах гэсэн чиглэл давамгайлах болсны шалтгаан нь Мао Зэдүн тэргүүтэй их үндэстний дээрэнгүй үзэлтнүүд Өвөр Монгол ард түмний үндэстний эрх чөлөөний хөдөлгөөний дотоод хэрэгт шууд оролцож өөрсдийн бодлогыг Улаанхүү зэрэг хүмүүсээр дамжуулан хүч тулган хүлээлгэх замаар явуулж ирсэнтэй холбоотой. Тэд уг ажлыг хийж гүйцэтгэхдээ цэргийн хүчээр сүрдүүлэн «Нэгдсэн Өвөр Монголын өөртөө засах орны төлөө» гэдэг хуурамч хөдөлгөөнийг сэдэн гаргаж дээр өгүүлсэн хоёр чиглэлийн төлөөлөгчдийн «Нэгдсэн их хурал»-ыг 1947 оны 4-р сарын 23-наас 5-р сарын 6 хүртэл Улаан хот (Вангийн сүм)-д хуралдуулж хятадын харьяаны Өвөр Монголын өөртөө засах орон байгуулж даргаар нь Улаанхүүг томилжээ.

ХКН анх байгуулагдсаны дараа үндэстний асуудлыг «марксч-ленинч» зарчмаар шийдвэрлэнэ хэмээн удаа дараа тунхаглаж байсан боловч хятадад ардын хувьсгал ялсны дараа баталсан 1954 оны үндсэн хуульд «БНХАУ бол олон үндэстний нэгдмэл улс мөн... цөөн тоот үндэстний оршин суудаг нутагт орон нутгийн өөртөө засах орон тогтоож болно. Үндэстний өөртөө засах орнууд бөл БНХАУ-ын салшгүй хэсэг мөн»¹ гэж заасан нь ХКН-ын дотор үндэстний асуудлаар маоист чиглэл шууд давамгайлах болсныг илтгэн харуулж байна. Тийнхүү Өвөр Монголын өөртөө засан тохинох эрх нь хятадын шууд харьяаны орон нутгийн өөртөө засах гэгчээр солигдож Өвөр Монголын ард түмэн маоист эрх баригчдаас явуулсан хятад биш үндэстнийг хүчээр уусгах бодлогод хэлмэгдэх замд эхлэн орсон ажээ. Өөртөө засан тохинох ямар ч эрхгүй автономит район төдий эрхийг Өвөр Монгол ард түмэнд олгосон нь үнэн чанартаа В. И. Лениний үндэстний асуудлыг шийдвэрлэн зохицуулах сургаалаас бүрмөсөн ухарсан, маоист бодлогын «нээлт» болжээ. Чухам тэр үеэс Бээжингийн эрх баригчид Өвөр Монголын ард түмнийг хүчээр уусгах ажилдаа шууд шургуу орсон бөгөөд уг ажлаа гүйцэтгэхдээ ил далд маш олон янзын арга хэрэглэсэн ажээ. Тухайлбал, үндсэн хүн амыг хятад нутгаар тарааж сарниулах, газар нутгийг нь хэсэглэх, монгол газар хятад иргэдийг нүүлгэн суурьшуулах ажлыг урамшуулах, үндэстний хэл, соёл, зан заншлыг хавчин гадуурхах, залуучуудыг нь цэрэгт дайчлан сургуульд сургах нэрээр хятадын дотоод нутгаар суурьшуулах, үндэстний боловсон хүчнийг нь ил далд аргаар хавчин устгах зэрэг олон талын хорт ажиллагаа угсруулан хийж иржээ. Маогийн бүлгээс Өвөр Монголд явуулж буй хүчээр уусгах бодлогыг газар нутаг, хүн ам, үндэстний боловсон хүчнийг устгаж, ард түмний соёл, зан заншлыг хятадчилж буй зэрэг хэдэн үндсэн чиглэлд хуваан авч үзэх нь зүйтэй юм.

1. Газар нутгийн талаар. Мао Зэдүн 1956 онд бичсэн «Арван их харьцаа» гэдэгтээ хятад үндэстний «хүн ам олон», цөөн тоот үндэстний «газар уудам, эд элбэг байдаг» хэмээн онцлон тэмдэглэсэн байдаг. Энэ нь хятад биш үндэстний газар нутаг, байгалийн баялгийг их хан (хятад)

¹БНХАУ-ын 1954 оны үндсэн хуулийн 3-р зүйл.

үндэстний мэдэлд хүчээр булаан авч хүн амыг нь хятадчилах гэсэн балмад бодлогын шууд илрэл, эхний дохио болсон байна.

1947 оны V сарын 1-нд Өвөр Монголын өөртөө засах орныг (ӨМӨЗО) байгуулахад Өвөр Монголын нийт хүн ам, газар нутгийг бүрэн хамарч чадаагүй байна. Тэр үед ӨМӨЗО-ы газар нутаг нь 500000 км², хүн ам нь хятад хүнийг оролцуулан 2 сая орчим байлаа.

БНХАУ байгуулагдсанаас хойш ӨМӨЗО-ы нутаг дэвсгэрийг эсвэл тэлэх, эсвэл багасгах журмаар олон дахин холхиулан өөрчилжээ. 1949 онд Ляо Бэй мужийн Жирэм аймаг, Халуун гол (Жэхэ) мужийн Зуу-уд аймгийг ӨМӨЗО-ы харьяанд шилжүүлжээ. 1949 оны XII сард БНХАУ-ын засаг захиргааны хуваарийг нийтлүүлэх үед ӨМӨЗО-ы нутаг дэвсгэр 700000 км² болж байсан бол түүнээс хойш 1950 онд Цахар аймгийн Долоннуур, Бао-чан, Хуадэ хошууг, 1954 онд Сүй юань мужийг тус тус ӨМӨЗО-д нэгтгэжээ. 1956 онд Жэхэ мужийн 6 хошуу, Эзэн нуурын автономит хошуу, Ганьсугийн автономит тойрог зэргийг ӨМӨЗО-д нэгтгэснээс болж Өвөр Монголын нийт нутаг нь 1,400000 гаруй км² хэмжээтэй¹ болж хятадын бүх нутгийн долооны нэг хувь болтлоо өргөсчээ.

1956 оны 4-р сард Ганьсу мужийн хэсэг нутгийг дан ганц Баян нуур аймаг болгон түүнийг бүхэлд нь ӨМӨЗО-ы нутагт шилжүүлжээ.²

ӨМӨЗО-ы газар нутгийг тэлэх ажил 1958 он хүртэл тасралтгүй явагдсан явдал нь улс төрийн нарийн учир утгатай байжээ. Юуны өмнө Өвөр Монголын нутгийг БНМАУ-ын газар нутгийн хэмжээнд хүртэл өргөтгөж, хүн амыг нь бас БНМАУ-ын хүн амаас олон болгохыг хичээжээ. Ийм замаар Өвөр Монголоор дамжуулан БНМАУ-ыг өөртөө нэгтгэх гэсэн маогийнхны улс төрийн далд бодлого шууд илэрснээс биш, Өвөр Монгол ард түмний өөртөө засан тохинох эрхийг хүндэтгэн үзэж авсан арга хэмжээ огт биш юм. Гэтэл маогийнхны тэр хорон санаат бодлого нэг их амжилт олоогүй учир 1958 оноос уул бодлогоо өөрчилж «зохицуулах бодлого» гэгч аргад шилжин орсон байна. Энэ арга нь тэлэх, өргөтгөх биш монгол аймгуудыг өөр хооронд нь нэгтгэх, бусад хятад хошуудад таслан шилжүүлэх арга байв. Ийм ажлыг 1958 оны IV—X сарын хооронд маш их хийжээ. Энэ үед Ордос монголын засаг захиргааны нэгжийг татан буулгаж, Баяннуур аймагт, Тал булгийн засаг захиргааны районд байсан 10 сянь, 1 хот, 4 хошууг Улаанцав аймагт шилжүүлсэн байна.³ Мөн энэ үед Цахар аймгийг татан буулгаж Шилийн гол аймагт нэгтгэжээ⁴ 1958—1966 оны хооронд газар нутаг, хүн амыг нь ихэсгэх, багасгах явдлаа түр зогсоож түүнээс илүү ноцтой аргыг сүвэгчилсэн бөгөөд энэ нь 1966 оны «соёлын хувьсгал» гэгчээр шууд илэрсэн юм.

«Соёлын хувьсгалын» үед ӨМӨЗО-ы нутаг дэвсгэрийг дур мэдэн тасдан хуваах ажил урьд өмнө үзэгдээгүй ихээр гаарав. Тухайлбал, 1969 онд ӨМӨЗО-ы нутаг байсан Жаруд хошуу⁵ Тунляо сянь,³ Тунляо хот⁷ зэргийг Гирин мужид хамруулсан ба 1970 онд Өвөр Монголын Зуу-уд аймгийг Ляонин мужид⁸ оруулсан байв.

«Соёлын хувьсгалын» үед ӨМӨЗО-ы нутгаас Хөлөнбуйрын 31,000 км², Зуу-уд аймгийн 170,000 км² нутаг зэрэг нийт дүнгээрээ 670000 км² нутгийг таслан зэргэлдээ хятад мужид нэгтгэжээ.

¹Советская историческая энциклопедия. М., 1966, IX боть, 608-р тал.

²Жэньминь жибао. 1956. V. 20.

³Жэньминь жибао. 1958. XI. 22

⁴Мөн тэнд.

⁵Жэньминь жибао, 1969. VII. 24.

⁶«_» 1970. III. 14

⁷мөн сонин 1970. V. 21

⁸3 мөн сонин 1970. V. 25

⁸Маоизм маогийнхан, УБ., 1974, 155 дахь тал

Хятадын удирдагчдын дур мэдэн ӨМӨЗО-ы нутгийг тасчин хуваасан нь 1972 онд Бээжинд хэвлэгдсэн хятадын газрын зургаас тодорхой харагддаг. Тэрхүү газрын зурагт Жирэм аймгийн Хорчин нарыг Гирин, Аяонин мужид; Баяннуур аймгийн Алшаа, Эзэн нуур хошууг бас өөр мужид тус тус хүчээр шилжүүлсэн байна.¹

Ийнхүү ӨМӨЗО гэдэг ойлголтонд одоо Улаанцав, Шилийн гол, Их зуу болон Баяннуур, Зуу-уд хоёр аймгийн хагас, Хөх хот, Бугат хэмээх хоёр том хот багтах төдий болжээ. Одоо ӨМӨЗО-ны нийт нутаг дэвсгэр бараг гурав дахин багасч 600000 км² болоод байгаа юм. Үүнийгээ «Монгол үндэстний хүсэлт, эдийн засгийн онцлогийг харгалзан хийсэн юм» гэж Бээжингийнхэн тайлбарладаг ажээ.

Бээжингийн эрх баригчид хятад биш ард түмний газар нутгийн талаар явуулах бодлогоо олон удаа өөрчилж нэмж хасч байсан нь өмнөх баримтаас тодорхой билээ. Энэ 1979 оны 6-р сард ӨМӨЗО-ы газар нутгийн талаар аанай л ээлжит холхиулалтаа хийлээ. ХКН-ын Төв Хороо, БНХАУ-ын Төрийн зөвлөлийн хамтарсан шийдвэрээр² ӨМӨЗО-ы нутгаас таслан авч хятад мужуудад нэгтгэсэн Зуу-уд, Жирэм, Хөлөнбуйр зэрэг гурван аймаг, Эзэнээ, Алшаа зүүн ба баруун хошуу зэрэг зургаан хошууг тус тус ӨМӨЗО-ы харьяанд буцаан нэгтгэх ажил хийв. Энэ шийдвэр хятадын суртал нэвтрүүлгийн ярьж байгаачлан хятад биш үндэстний талаар авч явуулж байгаа «энэрэнгүй ардчилсан» арга хэмжээ огт биш бөгөөд зөвхөн «тасчин хувааж, эзлэн захирах» маоист бодлогоос урган гарч байгаа тактикийн бас нэг хэлбэр төдий юм.

ӨМӨЗО-ы газар нутгийг дахин томсгож буй тактикийн энэ шинэ алхам нь хятад биш үндэстний зөрчлийг багасгах, үндэстний районы байгалийн нөөцийг шавхан дайчлах, хөрш зэргэлдээ улс орондоо өнгөлзөх санаархлаа өнгөн дээрээ нуун далдлах замаар нийгмийн амьдралыг цэрэгжүүлж, дайнд шургуу бэлтгэх явдлыг хүчтэй болгох хэтийн зорилготой нь холбогдон гарч ирж байгаа ээлжит ов мэх болох нь тодорхой байна. Хятадын удирдагчдын энэхүү дураараа аашлах авир зан, балмад хэрцгий ажил явууллага нь хятадын доторхи хятад биш үндэстэн түүний дотор хамгийн анхны өөртөө засах орон ӨМӨЗО-ы монгол ард түмний эсрэг явуулж байгаа ялт хэрэг бөгөөд энэ орон одоогийн байдлаар хөрш зэргэлдээ БНМАУ, ЗХУ-ын эсрэг түрэмгийлэл хийх түшиц газар болон нэгэнт хувираад байна.

II. Хүн амыг уусгах талаар. Бээжингийн эрх баригчдаас ӨМӨЗО-ы газар нутгийг ийнхүү ихэсгэж, багасгаж байгаа нь монгол хүн амыг уусган хятадчилах бодлоготой шууд уялдаж байна. ӨМӨЗО байгуулагдах үед монгол хүн ам хамгийн олонхи байсан бөгөөд энэ үед монгол хятад хүн амын харьцаа нь 13:1 байв.

Гэтэл 1948 оноос хойш хятад хүний тоо жил ирэх бүр улам өсөн нэмэгдсээр 1950 оны дунд үед нэг монгол хүнд 7 хятад хүн ноогдож улмаар 1967 он болоход монгол хятад хүний харьцаа 1:13 болж хувирчээ. 1979 оны эхний хагасын байдлаар авч үзвэл нэг монгол хүнд 30 гаруй хятад хүн ноогдож байгаа ба нутаг дэвсгэрийг нь өргөтгөх талаар саяхан гаргасан шийдвэртэй холбогдон хятад хүний эзлэх хувийн жин улам ч нэмэгдэж буй нь тодорхой. Хятад хүн амын хувийн жинг шуурхай өсгөх явдалд хүн ам олонтой хятад хошуудыг тус районд нэгтгэх явдал голлох үүрэг гүйцэтгэж байна. 1954 онд 2 сая 670 мянган хүнтэй Суй-юаннийг, 1955 онд Жэхэг, 1956 онд Нинся мужийн ихэнхийг тус тус Өвөр Монголд нэгтгэснээр ӨМӨЗО-д хятад хүний эзлэх хувийн жин эрс нэмэгджээ. 1953 оны тооллогоор ӨМӨЗО-ы хүн амын 85 хувь нь хятад байсан бол

¹ «Үнэн», 1972. IV. 5.

² Жэньминь жибао. 1979. VII.

1970 оны үе гэхэд 90 орчим хувь болсон ба 1979 онд 97 хувь хүрээд байлаа.

ӨМӨЗО анх байгуулагдах үед 2 сая гаруй хүн амтай байсан бол 1955 онд 6 сая 100 мянга, 1964 онд 10 сая болж, 1967 онд 13 сая хүрч¹ байсан байна. Харин ӨМӨЗО-ы нутгаас хятад мужуудад тасалж нийлүүлээд эргүүлж нэгтгээгүй байсан 1979 оны эхний хагасын байдлаар автономит район нь 12 сая орчим хүн амтай болжээ. Өвөр Монголд дунджаар 1 жилд хятадын дотоод нутгаас 50—60 мянган хятад нүүж ирдэг байснаа 1966—1967 оны хооронд ганцхан жилд сая гаруй хятад хүн Өвөр Монгол нутагт нүүн иржээ. Дээрх байдлаас дүгнэн үзэхэд 1947—1972 он хүртэл сүүлийн 25 жилд Өвөр Монголд нүүдэллэн ирсэн хятад хүний тоо өнгөрсөн түүхийн 320-иод жилийн дотор нүүж ирсэн хятад хүний тооноос даруй 10 гаруй дахин давжээ. ӨМӨЗО-ы нийт хүн амын өсөлт гэдэг нь жинхэнэ монгол хүний өсөлт биш, зөвхөн хятад иргэдийн тоо олширсноор тайлбарлагдана. БНХАУ-д 2,5 сая монгол хүн² оршин суудаг 1978 оны байдлаар Өвөр Монголд 400 мянган хүн оршин сууж³ байв. Гэтэл энэ 1979 оны эхний үеийн зарим мэдээнд ӨМӨЗО-ы нийт хүний тоо 300,000-аас илүүгүй⁴ гэсэн байна. 1976 он хүртэл хятадын хэвлэлд 2,5 сая монгол хүн БНХАУ-д байдаг тухай байнга бичиж байснаа 1978 онд гэнэт 1,5 сая монгол байдаг гэжээ.⁵ Энэ юугаар тайлбарлагдах вэ гэвэл нэг бол 1976 он хүртэл хятад дахь монгол хүний тоог хэт нэмж байсан байж болох, эсвэл 1960-аад оноос хойш 1 сая гаруй монгол хүнийг уусган усгасан байж болох юм. Бидний дүгнэлтээр бол аль ч талаар нь авч тайлбарлах үндэстэй бөгөөд сүүлчийн дүгнэлт нь бараг онох байх. 1960-аад онд ӨМӨЗО-д 1 сая 700 мянга гаруй монгол хүн оршин суудаг тухай бичиж байсан бол 1978 онд 400000 хүн оршин суудаг гэжээ. Ингэж сүүлийн хоёр жилд Хятад дахь монгол хүн 1 сая гаруйгаар хорогдож ӨМӨЗО-ы монгол хүн 870 мянган хүнээр хорогдсон байна. Гаднаас нь харвал ӨМӨЗО-ы хүн амын тоо ихээхэн өсч байгаа мэт боловч бодит байдал дээр монгол хүний хувийн жин байнга буурч байдаг байна. Тооны энэ мэт хэлбэлзлийн цаана үнэндээ хүчээр уусгасан, хүчирхийлэн устгасан олон бодит баримт нуугдаж байгаа юм. 1976 онд АНУ-аас эрхлэн хэвлүүлсэн «Монгол нийгэмлэг» сэтгүүлийн III ботийн 113-р талд «Өнөөгийн хятадад Өвөр Монголын монголчууд түүхийн өмнөх аль ч үед үзэгдээгүй ихээр хятад үндэстэнд ууслаа» хэмээн нилээд бодитой дүгнэлт хийсэн байдаг.

БНХАУ-д байгаа монголчууд ӨМӨЗО-оос гадна хятадын 8 мужид тархан суурьшдаг билээ. Автономит районы гадна оршин суудаг монголчууд Маогийн уусгах бодлогод нэн хүчтэй хэлмэгдэн уусч байна. Маогийнхан монгол үндэсний хүн амыг уусгахдаа монгол залуусыг хятад залуустай цус холилдуулах зорилгоор хятад хүнтэй ураг барилдуулах, хятад хүн ам шигүү суурьшдаг газарт «томилон» явуулж суурьшуулах ажлыг зохион байгуулж байна. Ер нь маогийнхан Өвөр Монгол хүмүүсийг биологийн талаар уусган хятадчилах явдлыг 1960 оноос эхлэн маш хүчтэй дэвэргэж байгаа баримт их бий. Тухайлан сүүлийн үеийн шив шинэхэн мэдээнээс үзвэл монгол хүн хоорондоо гэр бүл болоход заавал гэр бүлийн товчооны шийдвэр гаргуулах бөгөөд харин хятад хүнтэй ураг барилдвал ямар ч зөвшөөрөл хэрэггүй байдаг байна. «Соёлын хувьсгалын» үеэр улаан хамгаалагчид Өвөр Монголын нутагт ирж үймээн самуун дэгдээж байх үедээ монгол хүний цус адгуус малын цустай адил учир түүнийг

¹Жэньминь жибао, 1967. XI. 2.

²Гуанминь жибао, 1976. VIII. 7.

³Китай на стройке. 1978. № 1.

⁴Литературная газета. 1979. III. 4. № 11.

⁵Китай на стройке. 1978. № 1.

эрлийзжүүлэн сайжруулахын тулд хятад хүний цусаар тарих хэрэгтэй гэж хашгиралдаж байснаас ч уг асуудал тодорхой. Өвөр Монголын хүн амыг уусгаж, газар нутгийг нь эрхшээлдээ барьж байх гэсэн хятадын газрын эзэд, милитаристууд, Чан Кайшийн харгис бурангуй бодлогын шууд үргэлжлэл болох маогийн бүлгийн бодлогыг түүхийн бусад аль ч үетэй харьцуулэхад хамгийн хэрцгий адал балмад аргаар явагдаж байгаа юм. Өвөр Монгол ард түмэн түүхийн аль ч үед ийм аюултай бодлоготой хэзээ ч тулгарч байгаагүй гэж ярьдаг нь санамсаргүй хэрэг бишээ.

III. Үндэсний боловсон хүчнийг устгаж, ард түмний соёл, зан заншлыг хятадчилж байгаа талаар. Маогийнхнаас Өвөр Монголыг уусган хятадчилахдаа Өвөр Монгол ард түмний өвөрмөц соёлыг устгах, зан заншлыг нь хавчин гадуурхах, үндэсний хэл бичгийг нь мартуулах зэрэг олон аргыг хослон хэрэглэж ирлээ. Тэд Өвөр Монголын соёлыг устгах ажиллагаа явуулахдаа юуны түрүүнд үндэсний сэхээтнүүдийг үгүй хийх ажлыг онцлон анхаарсныг хэлэх хэрэгтэй. Маогийнхан ЗХУ ба БНМАУ-д мэргэжил олж авсан Өвөр Монголын олон сэхээтнүүдийг нутаг заан бүх насаар нь суулгах, нууцаар хорлох, шорон гянданд хорих замаар уусгах ажлаа хэрэгжүүлж үүнийгээ хятад ба хятад биш үндэстний ялгааг арилгаж байна хэмээн тайлбарлах болжээ. «Хятад үндэстэн ба үндэстний цөөнхийн ялгааг устгах явдалд намын зорилт оршиж байна»¹ гэдгээр халхавч хийж ӨМӨЗО-ы удирдах бүх тушаалыг хятад хүнд шилжүүлжээ. Түүгээр ч үл барам бусад үндэстний эсэргүүцлийн хөдөлгөөнийг дарахад монголчуудыг дайчлан оролцуулж байлаа. «ӨМӨЗО анх байгуулагдсан 1947 онд тус орны засгийн газрын гишүүн 21 хүний 18 нь монгол хүн байсан»² ба соёлын хувьсгалаас өмнө Өвөр Монголын нам захиргааны дээд байгууллагын удирдах тушаалд 40 монгол хүн ажиллаж байсан бол түүнээс хойш ӨМӨЗО-д монгол үндэстний боловсон хүчин бараг байхгүй болж одоо нэг, хоёрын зэрэг монгол хүний нэр сонсогдох төдий болж үлджээ. 1978 оны 1-р сарын 4-нд хуралдсан ӨМӨЗО-ы 5 дахь удаагийн ардын төлөөлөгчдийн хурлаар хувьсгалт хорооны бүрэлдэхүүнд сонгогдсон 15 хүнээс дөнгөж 3 нь монгол хүн байлаа³.

Тэрчлэн «Соёлын хувьсгал» гэгчийн үед Өвөр Монголын бүх шатны сургуулийн хичээлийг хятад хэлээр албадан явуулж, маогийн зохиолыг үгчилэн цээжлүүлэх явдал сургалтын гол агуулга болж байв. Бээжингийн эрх баригчид «Соёлын хувьсгал» эхлэснээс хойш Өвөр Монголын түүх дурсгалын зүйл, сүм дуганыг эвдэн бусниулж, зарим үнэт зүйлийг Бээжин рүү зөөн аваачжээ⁴. Бүтэн үлдсэн зарим сүм дуганд мөргөл үйлдэх, хятад хүний дэргэд хоорондоо эх хэлээр ярилцах, үндэсний бичиг үсэг, хувцас хунараа хэрэглэхийг чандлан хориглож, монголчууд үндэсний дуугаа дуулах, эрийн гурван наадам хийх, цагаан сараа бэлэг дэмбэрэлтэй угтах зэргийг зөвшөөрөхгүй болжээ.

1967 оноос Өвөр Монголд Мао Зэдүний үзэл санааны «их сургууль» байгуулах гэдэг халхавчаар хятадчилах ажлаа хүчлэн явуулж эхлэв. Энэ үеийн Өвөр Монголын сонинд: «Хичнээн ч их яаралтай амин чухал мянга түмэн ажил байсан ч түүнийгээ хойш тавьж оронд нь Мао даргын зохиолоос судалж түүний зааврыг биелүүлэх хэрэгтэй»⁵ гэжээ. Тэр үед Мао Зэдүний зохиолыг уншихгүй буюу түүний биеийг алдаршуулахыг үл хүсэгч тийм «нохойн толгойг» үзэл санааны хувьд давтан (дахин) хүмүүжүүлэх нэрээр хөдөлмөрийн лагерт хөөж, зарим хэсгийг бүр биеэр нь

¹Хунци (сэтгүүл) 1964. XII сар.

²Сасаити (сэтгүүл). 1971. № 10

³Жэньмннь жибао. 1978. I. 5.

⁴Маоизм, маогийнхан. УБ., 1972. 157-р тал

⁵Өвөр Монголын өдрийн сонин. 1968. IV. 16.

ч тонилгодог байв. Ийнхүү Маогийн зохиолыг бүх нийтээр хүчирхийлэн судлуулах нь:

1. Маогийн бодлогод итгэлгүй хүмүүсийг олж тогтоох;

2. Монгол гэр бүлийг үзэл суртлын хувьд үндсээр нь нураахад чиглэж байлаа. Хүмүүсийн дунд бие биедээ үл итгэх, хардах, сэрдэх, тагнах явдал газар сайгүй болов. Эх нь хүүгээ, эхнэр нь нөхрөө, хүү нь эцгээ ховлож мэдээлнэ. Ингэж гэр бүлийн дотор бие биеийн эсрэг чиглэсэн хоёр бүлэг бий болох бөгөөд энэ нь Маогийн аливаа нэгдмэл хүчнийг хагалан бутаргадаг түгээмэл аргын анхны хэлбэр болж байв. Маогийн бүлэг Өвөр Монголын хүн ам, соёлыг уусгах бодлого явуулахдаа 1957—1958 оны «суртал цэгцлэх хөдөлгөөн» гэгчийг ашиглан «цэцэг бүхэн дэлгэрч, эрдэмтэн бүхэн уралдаг» хэмээх уриагаар монгол үндэсний сэхээтнүүдийг «баруунтан» болгон хүчтэй хэлмэгдүүлсэн юм. Тэрчлэн 1958—1960 онд явагдсан эдийн засгийн алдаатай бодлого болох «Үсрэнгүй дэвшилт», 1966—1969 онд явуулсан «Соёлын хувьсгал», 1968—1969 оны «Дотоод Монголын ардын намыг малтах хөдөлгөөн» зэрэг улс төрийн удаа дараагийн кампаниар олон зуун эх оронч үндэсний сэхээтэн, удирдах ажилтныг хэлмэгдүүлжээ. Өгүүлж буй улс төрийн кампаниуд монгол үндэстнийг хүчээр уусгах их хятадын дээрэнгүй үзлийг ёс мэт дагалдуулан түүний агуулгыг эсэргүүцсэн бүхэн «баруунтан», «үндсэрхэг үзэлтэн», «ревизионист», «үндэстний нэгдлийг хагацуулагч», «хар хэрэгтэн», «буруу санаатан», «улсаас урвагч» зэрэг тоо тоймшгүй олон янзын зохиомол нэр зүүн хэлмэгдэж байв.

БНХАУ байгуулагдсанаас хойш маогийн бүлгээс явуулж ирсэн монгол үндэстнийг хүчээр уусгах бодлогыг Өвөр Монголын ард түмэн шийдвэртэй эсэргүүцсээр ирсэн байна.

Тухайлбал, 1957—1958 оны «суртал цэгцлэх хөдөлгөөн»-ий үед гарсан «цэцэг бүхэн дэлгэрч, эрдэмтэн бүхэн уралдаг» гэдэг улс төр, үзэл суртлын дайсагнасан кампанийн үед Өвөр Монголчууд их хан (хятад) үндэстний дээрэнгүй үзлийг шүүмжлэн, хятадын хүчээр уусгах бодлогын эсрэг шийдвэртэй тэмцэж байсан жишээ тэр үеийн хэвлэлд багагүй байдаг. «Монгол хэл устан хайлж байна. Монгол хэлийг сурах ажлыг хүчтэй болгоё»¹, «хятад хэл мэдэхгүй монгол хүнтэй ярих хүн бараг алга болжээ. Хятад хэл мэдэхгүй бол чадалгүйд тооцогдоно»², «хэрэв монгол нутгийн сургуулийн хүүхдүүд дээр сайн анхаарахгүй бол удахгүй хятад болох нь ямар ч маргаангүй»³, «Хөөрхий дээ! ӨМӨЗО-ы эзэн нь болох монгол үндэстний өдий монгол хүүхэд нь нийгэм дээр олбол зохих халамжийг олж чадахгүй байсаар хятадад хайлагдаж байхыг санахад үнэхээр хөөрхийлэлтэй бөгөөд харамсалтай биш үү»⁴, «Бүрэн бус мэдээгээр тус өөртөө засах орны 1 сая 100 мянган монголчуудаас төрөлх хэлээ таг мартсан хүмүүс 40 мянгад хүрч байна»⁵ гэх мэтээр Өвөр Монголын хэвлэлд илэрхий шүүмжлэн бичиж байсан нь Өвөр Монголын ард түмний хэл соёлыг уусган хятадчилж байсныг нотлох тодорхой баримт мөн.

1966 онд явагдсан «Соёлын хувьсгал» гэгч Өвөр Монголчуудыг хүчээр уусгах гэсэн олон жилийн оролдлого дээд цэгтээ хүртэл гаарсныг харуулсан юм. Энэхүү нугалаа завхралын үед Өвөр Монголын ард түмэн үндэснийхээ эрхийн төлөө их хятадын дээрэнгүй үзлийн эсрэг шийдвэртэй тэмцэж байсны жишээ багагүй бий. 1966 оны 8-р сард Хөх хотод дайн дажны байдалтай болж, газар сайгүй аллага таллага, үймээн самуун дэгдэж, хүмүүсийн ёолох хашгирах дуу өдөржин үргэлжлэснийг тэр үед

¹Өвөр Монголын өдрийн сонин. 1957. V. 21.

²Мөн сонин, 1957. VI. 12.

³Мөн сонин, 1957. X. 29

⁴Мөн сонин, 1957. VI. 13

⁵Мөн сонин. 1957. XII. 26.

Бээжинд гарсан нэг Дазыбао-д (том үсгийн сонин) Өвөр Монголын «...үхширмэл хорон санаатны бүлгээс Мао даргын улаан өнгөт бяцхан баатруудын эсрэг хийсэн тэвчиж болшгүй нүгэл мөн» гэж тэмдэглэжээ. Тэрчлэн «Бугатын хэрэг»¹, «Шилийн голын хэрэг»² болон 1967 оны 4-р сарын 25-наас 5-р сарын 12 хүртэл нийт Өвөр Монгол даяар гарсан бослого хөдөлгөөнүүд зэрэг үйл явдал газар сайгүй өрнөсөн боловч түүнийг зэвсгийн хүчээр цус урсган дарсан юм. Шорон гянданд хүн хорих явдал 1966 оны «соёлын хувьсгалаас» хойш асар их болжээ. Энэ үед хошуу, сум бригадын төв хүртэл шоронтой болсон байна. «Соёлын хувьсгалын» үед бүрэн бус мэдээгээр 60 гаруй мянган монгол хүн хэлмэгдсэн байна. Тэрчлэн «Соёлын хувьсгалын» үед Өвөр Монгол хүмүүсийг хятадууд 70 гаруй аргаар тамлан зовоодог³ байсан тухай хэсэг Өвөр Монголчуудаас дэлхийн Бүддистүүдийн холбооны чуулганд бичсэн захидалд өгүүлсэн байдаг.

х х х

Бээжингийн эрх баригчид Өвөр Монголын ард түмний тэмцэл хөдөлгөөнийг намжаах зорилгоор сүүлийн үед өмнө нь явуулж байсан хүчирхийлэх бодлогоо «зөөлрүүлэх» аргаар сольжээ. Тэд «соёлын хувьсгалаас» нааш явуулсан монгол үндэстний хэл, соёл, хэв заншлыг хориглосон ихэнх арга хэмжээгээ өнгөн дээрээ зогсоож байгаа дүр үзүүлж бүх бурууг нь Линь Бяо болон «Дөрвийн бүлэг» гэгчид тохон монгол хэл бичгийг хөгжүүлэх, монгол үндэстний боловсон хүчин бэлтгэх, үндэстний дээд сургууль байгуулах, тэрчлэн эрийн гурван наадам хийлгэх тухай багагүй ярих болжээ. Сүүлийн үед Өвөр Монголд Линь Бяо болон «Дөрвийн бүлгийн» хорлолоос болсон гэдэг нэрээр олон арван монгол хүмүүсийг нэр заан цагаатгах боллоо. Тэрчлэн цагаан сар, эрийн гурван наадам зэргийг зарим газар хийлгэж байна. Тухайлбал, 1977 онд Шилийн гол аймагт 512 бөх барилдаж Ядам гэдэг хүн түрүүлжээ. Зарим талаар ахицтай мэт ийм арга хэмжээ авч байгаа дүр үзүүлж байгаа нь маогийнхны ээлжит зальт аргын нэгэн болой. Тэд «соёлын хувьсгалаар» тарьсан нугалаа завхралаасаа ангижрах, өөрийн дотоодын түмэн зөрчлийг шийдвэрлэхэд хятад биш ард түмний дотор түр зуур ая тал засахыг оролдож байна.

Сүүлийн үед Бээжингийн эрх баригчид хүний эрх чөлөөг хязгаарласан тогтоол заалт хүртэл гаргаж байдаг болжээ. Жишээ нь 1979 оны 2-р сард ӨМӨЗО-ы намын хорооноос сэхээтний сахилга батыг сайжруулах 5 зүйлт тогтоол гаргаж түүний дөрөвдүгээрт нь «ихээр идэж уух, зочин дайлах, бэлэг дурсгал өгөх» зэргийг чандлан хоригложээ. Тэрчлэн монгол хүмүүсийг хятадын байнгын армид алба хаах, цэргийн чанартай үйлдвэрт ажиллуулах явдлаас аль болохоор зайлсхийж үүнийгээ «монгол хүн амыг өсгөх» гэсэн бодлого хэмээн тайлбарладаг байна. Гэтэл бодит байдал дээр монгол хүний тоо үргэлж буурч байдгийг анзаарахгүй өнгөрөх аргагүй билээ.

1977 оны 8-р сарын 1-нд ӨМӨЗО байгуулагдсаны 30 жилийн ойг Хөх хотод тэмдэглэн өнгөрүүлсэн юм. 30 жилийн ойд оролцохоор ирсэн төвийн төлөөлөгч Улаанхүү Өвөр Монгол нутгаар явж малчид тариачидтай уулзалт хийхдээ «..Та нар энэ районыг үр тарианы ба малын ашиг шимийн бааз...болгохоор чармайх хэрэгтэй»⁴ гэсэн юм. Энэ нь үнэн чанартаа мал малын билчээрийг үр тариагаар залгиулж, малчин монголчуудыг хятадын цэргийн хүнсний мал харгалзагчаар тохоон томилсон хэрэг юм.

¹Өвөр монголын өдрийн сонин. 1967. II. 4.

²1966 оны 8-р сарын 29-нд малчин ард, улаан хамгаалагч нарын хооронд болсон том тулалдаан.

³Утга зохиол урлаг сонин. 1973. 9. 3.

⁴Бээжингийн монгол хэлний нэвтрүүлэг 1977 оны 8-р сарын 7 (ШУА-ийн ДДСХ-ийн тусгай фонд)

Маогийнхан БНХАУ-ын харьяанд багтах олон үндэстэн түүний дотроос орон нутгийн өөртөө засах эрхтэй 5 районоос хятад биш үндэстнийг «хүчээр уусгах» бодлого хамгийн нааштай хэрэгжиж буй газрыг ӨМӨЗО гэж үзэж байна. Энэ ч учраас тэд Маогийн үндэстний бодлогыг хэрэгжүүлсэн үлгэр жишээ ууган район гэж Өвөр Монголыг нэрлэх ихээхэн дуртай байдаг.

Өвөр Монголыг маогийнхан хүчээр уусган хятадчилж байгааг нотлох энэ мэт арвин их мэдээ сэлт байгаа бөгөөд уул асуудлыг хойшид нарийвчлан судлах явдал нэн чухлаар шаардагдаж байна. Ах дүү социалист орны эрдэмтэд ялангуяа ЗХУ-ын эрдэмтдээс Өвөр Монголыг судлах талаар ихээхэн амжилт олж, үнэ цэнэтэй бүтээл туурвиж байна. Хөрөнгөтөн орны эрдэмтэд хүртэл Өвөр Монголыг хятадчилж байгаа байдлыг ихэд анхааран судалж эхлэв. Ийм нөхцөлд хөрш зэргэлдээ орших Өвөр Монгол ард түмний байдлыг бүх талаар нарийвчлан судлах явдал монгол эрдэмтэд бидний эрхэм зорилго гэж үзэж байна. Бид өөрсдийн судлагааг явуулахдаа бодит баримтанд тулгуурлан маогийнхны үндэсний дээрэнгүй бодлогыг шинжлэх ухааны үүднээс шүүмжлэн хэлэлцэх замаар явуулах нь зайлшгүй чухал юм.

Социалист нийгмийн үед хэдийгээр улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд бие биеэсээ ялгаатай онцлог зүйл нилээд байдаг боловч нийт үндэстний эрх ашиг нь социализм, коммунизм байгуулах, коммунист хөдөлгөөний интернационалч нийтлэг эрх ашигтай нийцэж байх ёстой билээ. Ер нь үндэстний асуудалд гагцхүү марксист-ленинист ёсоор хандвал үндэстэн бүрийг аль болохоор бүрэн дүүрэн цэцэглүүлж мандуулж болно гэдгийг түүхэн туршлага нотолж байна.

Иймээс үндэстний асуудал бол социалист орон бүрийн хөгжлийн нэг чухал асуудал бөгөөд түүнийг хэрхэн зөв шийдвэрлэх явдал тэдгээр орны нэгдэл, нягтрал хүч чадалтай нягт холбоотой юм. Гэтэл маогийн бүлгийнхэн их гүрний үндсэрхэг дээрэнгүй үзэл баримтласнаас болж үндэстний асуудлын тухай Лениний сургаалаас бүрмөсөн ухарч, хятадын олон үндэстэн ястны нэгдэн нягтрах, сайн сайхан аж төрж өөртөө засан тохинох эрхийг хохируулан бусниулах замд орсныг дээр өгүүлсэн баримт гэрчлэн харуулж байна.

Өвөр Монголын ард түмнийг уусган хятадчилж байгаа талаар МАХН-ын Төв Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ю. Цэдэнбал «Капитализмыг алгасан социалист нийгмийн байгуулалтанд шилжсэн нь» хэмээх бүтээлдээ «Орчин үед Өвөр Монголын автономит засаг нь хоосон нэр болон хүн амыг нь бүх шугамаар хүчээр уусган хятадчилж байна»¹ гэж дурдсан байна. Маогийн бүлгийн хүчээр уусган хятадчилахын эсрэг хятад биш олон үндэстэн ястны тэмцэл тасралтгүй өрнөж, бээжингийн удирдагчдын их хан үндэстний дээрэнгүй бодлогод удаа дараалан цохилт өгсөөр байна.

**О. Чулуун
М. Зэнээ**

**МАОИСТСКАЯ ПОЛИТИКА НАСИЛЬСТВЕННОЙ
АССИМИЛЯЦИИ КОРЕННОГО НАСЕЛЕНИЯ
ВНУТРЕННЕИ МОНГОЛИИ**

Резюме

Авторы статьи на большом фактическом материале анализируют великодержавно-шовинистическую политику маоистского руководства в отношении автономного района Внутренняя Монголия.

¹Намын амьдрал. 1975, № 2, 23—32-р тал.

Неханьские народы Китая, особенно коренное население Внутренней Монголии, веками подвергались национальному гнету. Великоханьский шовинизм, унаследованный нынешними китайскими правителями от своих предшественников, лег в основу национальной политики маоистов.

Маоисты неоднократно подвергали территорию Внутренней Монголии произвольным изменениям, вследствие чего площадь этого автономного района то сокращалась, то увеличивалась. Особое место в политике ассимиляции занимает переселение во Внутреннюю Монголию сотен тысяч ханьцев, в результате чего коренное население стало меньшинством в своем районе.

Ярким проявлением дискриминации монгольского народа в этом районе являются ущемление национальных интересов, прав, обычаев и религиозных верований монгольского народа, вытеснение из обихода и насильственная китаизация монгольского языка. Маоистская национальная политика имела особенно пагубные последствия в период «культурной революции».

В статье особо подчеркивается, что коренное население Внутренней Монголии никогда не мирилось с произволом китайских правителей, всегда упорно боролось за свои национальные интересы и права против великодержавного шовинизма. Широкое недовольствие народа Внутренней Монголии заставило нынешнее китайское руководство пойти на некоторые уступки. Но эти вынужденные тактические маневры отнюдь не означают того, что маоисты отказались от своей политики насильственной ассимиляции, а, наоборот, свидетельствуют о наиболее завуалированной, опасной форме ее проведения и о более изощренных методах и приемах великоханьского шовинизма.

Суть положения неханьских народов является малоизученной проблемой поэтому, заключают авторы, ее дальнейшее исследование имеет актуальное значение для раскрытия шовинистической сущности пагубной политики пекинского руководства по национальному вопросу.